



ХОТ БАЙГУУЛАЛТ ХӨГЖЛИЙН ГАЗАР

ХОТ БАЙГУУЛАЛТЫН МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТСИЙН
2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД


ЗГҮАХ-ийн 3.7.2 НЗДҮАХ-ийн 6.1.3.1. НХТЖҮЧ-ийн 9.3.2. Улсын кадастрын мэдээллийн нэгдсэн системд холбогдож, хэрэглээнд нэвтрүүлэн, гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийг шинэчлэн, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.

14.1 Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санг Улсын хот байгуулалтын кадастрын нэгдсэн системтэй холбож, хэрэглээнд нэвтрүүлэх хүрээнд:

1. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2020 оны А/29 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд Улсын хот байгуулалтын кадастрын системтэй мэдээлэл солилцох дундын серверийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын албан хаагчидтай хамтран сүлжээний холболтын бүтцийг шинэчлэн, дундын сүлжээний холболтыг дахин хийж бэлэн болгосон.
2. Уг ажлын хэсгийн хүрээнд “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн программ хангамжийн хөгжүүлэлт хийх” зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт холбогдох санал өгч тус газарт албан бичгээр хүргүүлсэн.
3. Мөн 5 удаагийн хамтарсан уулзалт хийж, Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системийн бүтэц, өгөгдөл сангийн зохион байгуулалтын талаар танилцуулж, Улсын хот байгуулалтын кадастрын нэгдсэн систем хөгжүүлэлтийн ажлын явцтай танилцан, дундын серверт Хот байгуулалтын мэдээллийн сангийн суурь өгөгдлүүд болон хаяг дугаартай барилгын мэдээллийг шинэчлэн байршуулсан.
4. Ажлын хэсгийн хүрээнд 8 дугаар сарын 3-ны өдөр Хот төлөвлөлтийн хэлтэс, Хот дахин хөгжүүлэх хэлтсийн ахлах мэргэжилтнүүд болон тус хэлтсийн 4 албан хаагч хамтарсан уулзалтад оролцож, Улсын хот байгуулалтын кадастрын нэгдсэн системийн ажлын явцтай танилцаж холбогдох саналуудаа өгсөн. Уг ажилд шаардлагатай мэдээ, мэдээллийг Хот байгуулалтын мэдээллийн сангаас тоон хэлбэрээр ГЗБГЗЗГ болон Улсын Хот байгуулалтын кадастрын нэгдсэн системийг хөгжүүлэгч компанид хүргүүлэн хамтран ажиллаж байна.



5. Улсын Хот байгуулалтын кадастрын нэгдсэн системийг хөгжүүлэгч Топмэп ХХК-ийн ажилчид болон ГЗБГЗЗГ-ын Хот байгуулалтын кадастрын хэлтсийн холбогдох албан хаагчидтай Барилгын зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулах хамтарсан уулзалтууд хийж тус газрын Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системийн бүтэц, өгөгдөл сангийн зохион байгуулалтын талаар танилцуулж, жишээ болгон барилга байгууламжийн дэд сангийн атрибут мэдээлэл болон Баянгол дүүргийн өгөгдлийг *.xml форматаар Топмэп ХХК-д өгсөн.



Объект ID	Объект Нэр	Хот Байгуулалтын Мэдээлэл	Дэд Сангийн Атрибут
1	Барилга
2	Хот байгуулалт
3	Хот байгуулалт
4	Хот байгуулалт
5	Хот байгуулалт
6	Хот байгуулалт
7	Хот байгуулалт
8	Хот байгуулалт
9	Хот байгуулалт
10	Хот байгуулалт

6. Дундын серверт байршуулсан өгөгдөл мэдээллийг www.urban.gov.mn цахим хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэйгээр харуулах туршилтыг эхлүүлсэн.

Уг систем хэрэглээнд нэвтэрснээр:

- Иргэн, хуулийн этгээд төрд байгаа мэдээллийг дахин илгээх шаардлагагүйгээр цахим үйлчилгээ авах
- E-gazag.gov.mn системтэй холбогдож өөрийн эзэмшил газрын мэдээллийг татан Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл, хамгаалалтын зурвастай давхцаж байгааг шалган барилгажих талбайг тооцоолох
- Иргэн, хуулийн этгээд өөрийн илгээсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн явцыг хянах боломжтой.



14.2 Нийслэл, дүүргийн хаягийн зургийг засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх, холбогдох саналыг хүргүүлэх хүрээнд:

1. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1048 захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2 дах хурлыг 1 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж, ажлын төлөвлөгөөг

- шинэчлэн батлуулан дүүргүүдийн Засаг дарга нар болон Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт зохицуулалтын газарт албан бичгээр хүргүүлсэн.
- Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/11 дүгээр тушаалаар удирдамж батлагдсантай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Геокад ХХК-н холбогдох албан хаагчидтай хаягжуулалтын ажлын талаар нийт 5 удаагийн уулзалт хийсэн ба хаягийн мэдээллийн систем болон нийслэлийн хаягийн зурагт тусгах саналыг тухай бүр хүргүүлж ажилласан.
 - Дээрх ажлын хүрээнд Геокад ХХК-н гүйцэтгэсэн нийслэлийн хаягийн зургийн гудамж, талбайн эхлэл, төгсгөлийг батлагдсан тогтоолтой тулгаж, шинэчлүүлэх саналаа тус компанид хүргүүлсэн.
 - Мөн хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэгдсэн барилга байгууламж, авто зам, гудамж талбайн нэршлийн шинэчлэгдсэн мэдээллийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Кадастрын хэлтэс болон Орон зайн дэд бүтцийн хэлтэс, Геокад ХХК-д тус тус тоон байдлаар хүргүүлсэн.
 - Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны удирдлагууд, холбогдох албан хаагчидтай хийсэн уулзалтаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-д өөрчлөлт оруулж, нийслэл, дүүргийн хаягийн зургийг шинэчлэх болсон тухай мэдэгдсэн тул Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1048 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гүйцэтгэх ажил дууссан.
 - Улсын хаягийн мэдээллийн нэгдсэн сантай Барилгын мэдээллийн санг холбох ажлыг эрчимжүүлэх талаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Кадастрын хэлтсийн дарга болон хаягийн мэдээллийн сангийн хөгжүүлэлтийг хариуцагч Софт мастер ХХК-н ажилтантай 12 дугаар сарын 7-ны өдөр уулзалт хийж, цаашид үйл ажиллагаандаа нэвтрүүлэх талаар хамтран ажиллахаар болсон.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

2.12 Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, талбай, хотхон хорооллыг нэршүүлэх, нэрэмжит болгох ажлыг зохион байгуулж, барилга байгууламжид хаяг дугаар олгох ажлыг хариуцан гүйцэтгэх:

- Гудамж талбайн нэрийн асуудал эрхэлсэн комиссын хурлыг нийт 5 удаа цахим хэлбэрээр зохион байгуулж, дараах 7 гудамж, замыг нэршүүлэх асуудлыг хэлэлцүүлсэн. Үүнд:
 - Хан-Уул дүүргийн 17 дугаар хороо, Их Монгол улсын гудамжнаас баруун тийш Зайсангийн гудамж хүртэлх 2,3 км гудамжийг Бүгд Найрамдах Польш Улсын ерөнхийлөгч асан Лех Качиньскийн нэрэмжит болгох,
 - Одоогийн Өлзийтийн зам буюу Нисэхийн аюулгүйн тойргоос урагш Жаргалантын амруу эргэх уулзвар хүртэлх 3341м гудамжийг Архивчдын гудамж,
 - Жаргалантын амруу эргэх уулзвараас цааш Өлзийтийн шалган нэвтрүүлэх товчоогоор гарч Өлзийт хорооллын урдуур Шувуун Фабрикийн зам хүртэлх 16420м гудамжийг Өлзийтийн зам болгох өөрчлөх,
 - Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөөнөөс УБЦТС ТӨХК-н баруун талаар хойш Үйлдвэрийн гудамж хүртэлх 525м гудамжийг П.Дамдины нэрэмжит болгох,
 - Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Б.Алтангэрэлийн гудамжнаас МАН-ын төв байрны ар тал, Соёлын төв өргөөний зүүн талаар Ерөнхий сайд Амарын гудамж хүртэл 250 м гудамжийг Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн Б.Энхтүвшингийн нэрэмжит болгох,
 - Баянзүрх дүүргийн 5 дугаар хороо, Ж.Лхагвасүрэнгийн гудамжнаас зүүн тийш Рерихийн гудамжны төгсгөл, Г.Лувсанцэвээний гудамж хүртэлх 510м гудамжийг Зөвлөлтийн эмч, тахал судлалын эмч Любовь Сергеевна Соболевагийн нэрэмжит болгох,
 - Хан-Уул дүүргийн 17-р хороо, Зайсангийн гудамжнаас зүүн тийш далан дээгүүр Хан хиллс хотхоны арын авто замын уулзвар хүртэл 1,1 км гудамжийг Бүгд

Найрамдах Польш Улсын нэрт хөгжмийн зохиолч, төгөлдөр хуурч Фредерик Шопенийн нэрэмжит болгох.

2. Нэрийн комиссын хурлаас дэмжигдсэн шинээр нэршүүлэх 3 гудамж, 1 замын байршил өөрчлөх асуудлыг холбогдох хууль, журмын дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Хэлний бодлогын Үндэсний зөвлөл, харьяа дүүргийн Засаг даргын Тамгын газар болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тус тус санал авч нэгтгэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчийн Хуралд өргөн барьж хэлэлцүүлэн 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 98, 11 дүгээр сарын 19-ний өдрийн 157 дугаар тогтоолуудаар батлагдсан.



3. Тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Барилга, хот байгуулалтын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, ЦЕГ-ын Тээврийн цагдаагийн алба, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Авто зам, хөгжлийн газар, Нийслэлийн Архивын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Баянзүрх болон Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Архивын Ерөнхий газар зэрэг 14 байгууллагад албан бичгээр хүргүүлсэн.
4. П.Дамдин, Д.Энхтүвшин, Лек Каченьский нэрэмжит гудамж нэршүүлэх асуудлууд Нэрийн комиссын хурлаар дэмжигдээгүй тул хурлын шийдвэрийг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд тус тус албан бичгээр хүргүүлсэн.
5. Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах бичил цэцэрлэгийг нэршүүлэх хүсэлтийг иргэн Баясгалан, Байгалмаа нараас ирүүлсний дагуу 2 дугаар сарын 5-ны өдөр Хот төлөвлөлтийн ахлах мэргэжилтэн Д.Хан-Уул, мэргэжилтэн Энхнаран нарын хамт уулзалт хийсэн. Уулзалтаар хэлэлцсэний дагуу дээрх бичил цэцэрлэгийг нэршүүлэхэд Соёлын яам, Монгол кино нэгтгэл, Нийслэлийн Соёл урлагийн газар, Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Музей зэрэг байгууллагуудад албан бичиг хүргүүлж нэрийн санал авч танилцуулга бэлтгэсэн, шүүхийн маргаан шийдвэрлэгдсэний дараа Нэрийн комиссын хуралд танилцуулахаар болсон.
6. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраас ирүүлсэн албан бичгийн хүрээнд Улаанбаатар хотод гадаад хот, хүний нэрээр нэршүүлсэн гудамжны нэрийн талаар Хэл бичгийн хүрээлэн болон Хэлний бодлогын Үндэсний зөвлөлөөс санал авч, Нэрийн комиссын хуралд танилцуулахаар бэлтгэж байна.
7. Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний Дүнжингарав, Драгон, Мишээл, Оргил, Баянгол төвүүд, 1800-1200 дугаар, E-mongolia.mn цахим хуудсаар ирүүлсэн хаяг дугаар хүссэн **1230** хүсэлтийг хүлээн авч **1388** барилгад шинээр, **152** барилгад дахин тодорхойлолт гаргаж өгөв. /**33 769 340** төгрөг/

2.13 Барилга байгууламжийн тэг тэнхлэгийн актыг мэдээллийг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэж Хот байгуулалтын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх үзүүлэх:

1. Барилга, байгууламжийн тэг тэнхлэгийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээлгэн өгөх **303** иргэн, хуулийн этгээдийн **583** блок барилга байгууламжийн актыг хүлээн авч Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд бүртгэн, **303 акт** үйлдэж өгөв.

2.14 Гүйцэтгэлийн байр зүйн зургийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээн авч бүртгэн мэдээллийн сангийн суурь өгөгдлийг шинэчлэх, баяжуулах :

1. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний **2654** байр зүйн зураг хүлээн авч хот байгуулалтын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг **796.2 га** талбайгаар шинэчлэн баяжуулж, **2092 акт** үйлдсэн.
2. Инженерийн шугаман байгууламж, барилга байгууламжийн төлөвлөлт, ашиглалтын үеийн геодезийн хяналтын хэмжилтийг 5 байршил-д гүйцэтгэсэн.

2.15 Хот байгуулалтын мэдээллийн сан дах зураг болон тоон мэдээ, мэдээллээр холбогдох журмын дагуу үйлчилгээ үзүүлэх:

1. Ирсэн хүсэлтийн дагуу **145** иргэн, хуулийн этгээдэд байр зүйн дэвсгэр зургийг тоон болон хэвлэмэл байдлаар хүлээлгэн өгсөн. /12 560 169 төгрөг/
2. Сонголт дизайн ХХК-тай “Хот байгуулалт, хөгжлийн газрын нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах тухай” гэрээ байгуулан 2021/12 дугаартай акт үйлдэж зүйн зургийг тоон хэлбэрээр хүлээлгэн өгөв.
3. Ус суваг удирдах газар, Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-тай 2019 онд байгуулсан “Хот байгуулалт, хөгжлийн газрын нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах тухай” гэрээний дагуу акт үйлдэж байр зүйн зургийг тоон хэлбэрээр хүлээлгэн өгсөн.
4. Ус суваг удирдах газартай 2019 онд байгуулсан “Хот байгуулалт, хөгжлийн газрын нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах тухай” гэрээг гэрээ дүгнэсэн протоколоор 3 жил сунган, акт үйлдэж байр зүйн зургийг тоон хэлбэрээр хүлээлгэн өгөв.
5. Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-тай 2019 онд байгуулсан “Хот байгуулалт, хөгжлийн газрын нууцад хамаарах мэдээллийг хадгалах, хамгаалах, ашиглах тухай” гэрээний дагуу байр зүйн зургийг тоон хэлбэрээр хүлээлгэн өгөв.
6. Нийслэлийн Авто замын хөгжлийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу тус газартай байгуулсан “Газарзүйн мэдээлэл солилцох талаар хамтран ажиллах тухай” гэрээ байгуулж, 2021/03 дугаартай акт үйлдэн нийт 25 төрлийн мэдээллийг тоон хэлбэрээр хүлээлгэн өгөв.
7. Албан бичгийн дагуу **17** байгууллагад хот байгуулалтын мэдээллийн сангаас **91** төрлийг мэдээ мэдээллийг тоон байдлаар хүлээлгэн өгсөн. Үүнд:
 - Одон орон, геофизикийн хүрээлэнд хаяг дугаартай барилгын мэдээллийг /*gdb, *excel өргөтгөлтэйгөөр/,
 - Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2021/02 дугаартай актаар орон зайн 27 төрлийн мэдээлэл,
 - Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт, зохицуулалтын газарт Туул гол дагуух 2558 га талбайн 1:1000 масштабтай байр зүйн дэвсгэр зургийг тоон хэлбэрээр 2021/04 дугаартай актаар, мөн хаяг дугаартай барилгын мэдээллийг 2 удаа,
 - Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-т төвийн 6 дүүрэг дэх төлөвлөгдсөн барилга, байгууламжийн мэдээллийг,
 - Налайхын Дулааны станц ТӨХК-д Налайх дүүргийн дулааны шугам сүлжээ, орон сууцны барилгын мэдээллийг ,*dwg хэлбэрээр,
 - Диспетчерийн үндэсний төвд УБ хотын төвийн 6 дүүргийн хаяг дугаартай барилга, дулааны шугамын мэдээллийг,
 - Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд Хот байгуулалтын мэдээллийн сангаас 12 төрлийн хамгаалалтын зурвасын мэдээллийг тоон байдлаар,

- Нийслэлийн Хот байгуулалт, судалгааны институтэд Хот байгуулалтын мэдээллийн сангаас гамшгийн үеийн дуут дохиоллын байршлын мэдээллийг тоон байдлаар,
 - Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 4 төрлийн мэдээллийг тоон байдлаар,
 - Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын ажлын хэрэгцээнд зориулан замын мэдээллийг тоон хэлбэрээр,
 - Ус сувгийн удирдах газарт 5 төрлийн мэдээллийг 2021/08 дугаартай актаар,
 - Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д 4 төрлийн мэдээллийг 2021/07 дугаартай актаар тус тус хүлээлгэн өгөв.
 - Ажлын хэрэгцээнд зориулан нийслэлийн 9 дүүргийн кадастрын мэдээллийг ,*kmz хэлбэрээр, мөн төвийн 6 дүүргийн 34 байршил дахь газар эзэмшигчийн мэдээллийг Газрын кадастрын мэдээллийг сангаас шүүж Хот төлөвлөлтийн хэлтэст өгөв.
 - Үндэсний статистикийн хороонд Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэлтэй барилга, байгууламж, явган хүний замын мэдээллийг албан бичгээр хүргүүлэв.
 - “Тавантолгой төмөр зам” ХХК-аас ирсэн хүсэлтийн дагуу Богдхан төмөр замын ажлын хүрээнд 7 төрлийн мэдээллийг албан бичгээр хүргүүлэв.
 - Нийслэлийн Байгаль орчны газраас ирсэн хүсэлтийн дагуу Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн зуслангийн бүсэд амины сууцны зориулалтаар архитектур төлөвлөлтийн даалгавар авсан барилгын мэдээллийг албан бичгээр хүргүүлэв.
8. Хот байгуулалтын мэдээллийн сан дахь орон зайн өргөдлөөр сэдэвчилсэн зураг бэлтгэн **25** байгууллагад **108ш** зургийг хэвлэмэл болон тоон хэлбэрээр хүлээлгэн өгсөн. Үүнд:
- Тээврийн Цагдаагийн албанаас ирүүлсэн албан бичгийн дагуу сэдэвчилсэн зургийн эх бэлтгэн 0,9x3м хэмжээгээр 1ш, 1.8x1.8м хэмжээгээр 2ш, 0.9x2м хэмжээгээр 1ш, 1.8x2.7м хэмжээгээр 1ш, 1.4x2.4м хэмжээгээр 1ш, нийт 6 ш зургийг хэвлэмэл болон зураг хэлбэрээр,
 - Баянзүрх дүүргийн 21 дүгээр хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу тус хорооны зургийг А1 хэмжээгээр бэлтгэн jpg хэлбэрээр,
 - Газарзүй геоэкологийн хүрээлэнгээс ирүүлсэн албан бичгийн дагуу Шархад орчмын байрзүйн дэвсгэр зургийг ,*pdf хэлбэрээр,
 - Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт байрлах хүнс болон барааны томоохон зах, худалдааны төвийн байршлыг харуулсан сэдэвчилсэн зураг бэлтгэн 1.8x3.0 метр хэмжээгээр хэвлэж Нийслэлийн Засаг даргын орлогч Ж.Сандагсүрэнд,
 - Улаанбаатар хотын нийтийн тээврийн сүлжээ болон хороодын заагийг харуулсан сэдэвчилсэн зураг бэлтгэн А0 хэмжээгээр 7ш хэвлэж Нийслэлийн Нийтийн тээврийн газарт /Нийслэлийн Зам, тээврийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Б.Одсүрэнд/,
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт нийслэлийн засаг захиргааны сэдэвчилсэн зургийг 1.8x2.4м хэмжээгээр 3 хувь хэвлэж, 1.5x0.9 хэмжээтэй 5ш зураг, А2 хэмжээтэй 12ш зураг, Соён гэгээрүүлэх тасагт А3 хэмжээтэй 1ш сэдэвчилсэн зураг бэлтгэж *png өргөтгөлтэйгөөр,
 - Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд Улаанбаатар хотын 6 дүүргийн А0 хэмжээтэй 6ш сэдэвчилсэн зураг хэвлэмэл байдлаар, 2.6x3.5м хэмжээтэй 1ш, 900x1500 хэмжээтэй 1ш хэвлэмэл болон тоон байдлаар,
 - Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-аас ирсэн албан бичгийн дагуу Сонгинохайрхан дүүргийн 20, 32 дугаар хороон дахь газар доорх шилэн кабелийн зургийг А0 хэмжээгээр 1ш бэлтгэж тоон байдлаар,
 - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд Сүхбаатар дүүрэг дэх өгөгдсөн байршлын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний авто замын сэдэвчилсэн А3 хэмжээтэй 1 хувь хэвлэж,
 - Нийслэлийн Мэдээлэл технологийн газарт А0 хэмжээтэй зураг 3ш хэвлэж,
 - Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд А0 хэмжээтэй зураг 2ш хэвлэж,

- “Грандлайн” ХХК-д албан бичгийн дагуу Баянзүрх дүүргийн 12 дугаар хорооны 0.9x2.3м хэмжээтэй сэдэвчилсэн зураг 2ш хэвлэж /543800 төг/,
- Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн ажлын албанд Улаанбаатар хотын нэршүүлсэн болон нэргүй гудамжны зургийг АЗ хэмжээгээр бэлтгэн зураг хэлбэрээр тус тус хүргүүлсэн.
- Мөн ажлын хэрэгцээнд зориулан Ерөнхий архитекторын ажлын албанд А0 хэмжээтэй 15ш, А1 хэмжээгээр 3ш зураг,
- Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны Засаг даргад тус хорооны А0 хэмжээтэй 1ш сэдэвчилсэн зураг бэлтгэж 1 хувь хэвлэж, /254,700 төгрөг/
- Сонгинохайрхан дүүргийн 40 дүгээр хороонд тус хорооны А0 хэмжээтэй 1ш зураг бэлтгэж 1 хувь, АЗ хэмжээтэй 22ш зураг бэлтгэж 22 хувь хэвлэж,
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст Улаанбаатар хотын А0 хэмжээтэй 1ш сэдэвчилсэн зураг бэлтгэж 1 хувь хэвлэж,
- Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Хууль эрх зүй, хяналт үнэлгээний хэлтэст Улаанбаатар хотын 3,8x1,8м хэмжээтэй 1ш, 1x1,6м хэмжээтэй 1ш сэдэвчилсэн зураг бэлтгэж тоон байдлаар,
- “Өгөөж хишиг” ХХК-д тус компанийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 30А, 44 дүгээр байрны АЗ хэмжээтэй 1ш сэдэвчилсэн зураг бэлтгэж 1 хувь хэвлэж, /39,313 төгрөг/
- Нийслэлийн Онцгой байдлын газарт нийслэл хотын Онцгой байдлын үед ашиглах А0 хэмжээтэй 8ш, 1.8x2.8 хэмжээтэй 1ш сэдэвчилсэн зураг бэлтгэж 9 хувь хэвлэж өгөв.

2.16 Хот байгуулалтын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх, шинэчлэн баяжуулах, журмын дагуу үйлчилгээ үзүүлэх:

1. Хот байгуулалтын мэдээллийн сан дахь орон зайн дэд мэдээллийн санг шинэчлэх ажлын хүрээнд шинээр хаяг дугаар авсан **1388** барилгын мэдээллээр барилгын мэдээллийн санг, 171 хорооны хүн амын мэдээллээр нийгэм статистикийн мэдээллийн санг, автобус бааз, автобусны зогсоол, маршрутын мэдээллээр нийтийн тээврийн мэдээллийн санг, шинээр нэршүүлсэн гудамжны нэршил болон нийслэл дэх сургууль, цэцэрлэгийн хамрах хүрээний зураглалаар тус тус баяжуулсан.
2. Мөн Хот байгуулалтын мэдээллийн санд байр зүйн зургаар хүлээлгэн өгсөн 20,4 км авто зам, 19,5 км холбооны шугам, 31,4 км цахилгааны шугам, 1,5 км далан суваг, 6,2 км ус зайлуулах шугам, 28,8 км дулааны шугам, 20,8 км ариутгах татуурга, 12.5 км усан хангамжийн мэдээллээр тус тус шинэчилсэн.
3. Барилга байгууламжийн, хороодын хүн амын, нийтийн тээврийн, гудамж талбайн, гэрэлтүүлэг, шугам сүлжээний хамгаалалтын зурвасын, тусгай хамгаалалттай газар нутгийн зэрэг орон зайн 7 төрлийн дэд мэдээллийн сангийн өгөгдлийг шинэчлэв.
4. Мөн Улаанбаатар хот дах галын гидрант, гамшгийн үеийн дуут дохиоллын байршлын мэдээллийг шинээр оруулж, сургууль, цэцэрлэгийн хамрах хүрээний зураглалыг гаргаж Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд бүртгэж оруулав.
5. Хот төлөвлөлтийн хэлтэс болон Барилгын чанар, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн хүсэлтийн дагуу зөвшөөрөлгүй барилга, байгууламжийг тодруулах, орон зайн дүн шинжилгээ хийхэд шаардлагатай байр зүйн зургийг 11 байршилд хийж гүйцэтгэсэн.
6. Газрын даргын 2020 оны А/85 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд:
 - Хот байгуулалтын мэдээллийн менежментийн систем дэх барилгын мэдээллийн сангийн “Төлөвлөгдсөн” хэсгээс давхардсан, төлөвлөлт өөрчлөгдсөн, Архитектур төлөвлөлтийн даалгавар хүчингүй болсон 475 барилга, тохижилт, дэд бүтцийн төлөвлөлтийн трассыг устгаж цэвэрлэв.
 - НИТХ-ын 2019 оны 8/27, 25/21 дүгээр тогтоолын дагуу нийт 2550 барилгын хорооны мэдээллийг шинэчлэв.

2.17 Байгууллагын гадаад болон дотоод сүлжээний зохион байгуулалт, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, сервер, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах, хот байгуулалтын мэдээллийн сангийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, нөөцлөх ажлыг зохион байгуулах:

1. Байгууллагын сервер, сүлжээний тоног төхөөрөмжүүдийн тасралтгүй хэвийн найдвартай ажиллагааг хангах болон хадгалалт хамгаалалтыг сайжруулах, программ хангамж, техник хангамж, эд анги, дотоод сүлжээний аюулгүй байдлыг тогтмол ханган ажиллаж байна.
2. UB ERP нийслэлийн дотоод удирдлагын нэгдсэн систем байгууллагын дотоод сүлжээнд шинээр томилогдсон 22, ажлаас чөлөөлөгдсөн 24, шилжүүлэн томилогдсон 20 албан хаагчдын нэвтрэх, хандах эрхийг тогтоож өгсөн.
3. Цаг бүртгэлийн машинаас албан хаагчдын мэдээллийг өдөр бүр татаж UBERP системд оруулж байна.
4. Хот байгуулалтын мэдээллийн менежментийн өгөгдлийн бааз хадгалагддаг серверийн гэмтэлтэй 7ш хатуу дискүүдийг сольж хэвийн ажиллагаанд оруулсан.
5. Хот байгуулалтын мэдээллийн менежментийн систем байршиж буй серверийн хатуу дискийг шинэчлэн зохион байгуулсантай холбоотойгоор серверт өгөгдлийн баазуудыг нөөцөлж дахин байршуулан холболтыг хийсэн.
6. Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд хандан ажиллах албан хаагчдын эрхийг ажлын байрны тодорхойлолтын дагуу шинэчлэн тогтоож өгсөн. Мөн барилгын цахим архивын нөхөн бүрдүүлэлтэд зориулж зарим мэргэжилтэнд хандах эрхийг түр хугацаанд нээж өгсөн.
7. Хортой кодоос хамгаалах Эсэт программын 110 ширхэг эрхийг худалдан авч албан хаагчдын компьютерт суулгасан.
8. Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системийн өгөгдөл, домэйн болон давхаргын мэдээллийг тухай бүрд шинэчилж ажилласан.
 - Газрын кадастрын зарим өгөгдлүүд *.gdb форматтай байсныг ба сервис болгон өөрчилсөн. Мөн кадастрын мэдээллийг 2 удаа шинэчилсэн.
 - “Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” давхарга дахь Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон Бүсчлэлийн дэд давхаргын мэдээллийг холбогдох мэргэжилтнээс авч шинэчилсэн.
 - Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системд нийслэлийн Засаг даргын 2021 оны А/653 дугаар захирамжаар батлагдсан “Хот байгуулалтын зарим үйл ажиллагааг түр зогсоосон бүс”-ийн мэдээллийг нэмсэн. Мөн 7 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлийн мэдээллийг шинэчилж оруулсан.
 - “Агаарын зураг” давхаргын сервисийг бэлтгэсэн дундын серверт байршуулж холболт хийсэн.
 - Барилгын анхны болон одоогийн зориулалт домэинд 2 зориулалтын төрөл шинээр нэмсэн.
 - Барилгын зип код домэинд нэг талбар шинээр нэмсэн.
 - Бүх прожектэд Барилгажихыг хориглосон бүс, Хүн амын нягтрал хэтэрсэн байршил, сургууль, цэцэрлэгийн хамрах хүрээ зэрэг дэд давхаргуудыг байнга нээлттэй харагддаг байхаар шинэчилсэн.
 - Хот байгуулалтын мэдээллийн менежментийн систем дэх барилгын мэдээллийн сангийн төлөвлөгдсөн хэсгээс давхардсан, төлөвлөлт өөрчлөгдсөн, Архитектур төлөвлөлтийн даалгавар хүчингүй болсон 477 барилга, тохижилт, дэд бүтцийн төлөвлөлтийн трассыг устгаж цэвэрлэв.
9. Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системийн найдвартай хэвийн ажиллагааг хангах дэд программ хангамжийг боловсруулах ажлын хүрээнд:
 - E-Registration программ хангамжийн “Барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээ” дэд программ хангамжийг шинэчлэн хот байгуулалтын мэдээллийн менежментийн системийн барилгын мэдээллийн сантай холбосон
 - E-Registration программ хангамжийн “Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэгдсэн тухай акт” болон “Тэг тэнхлэг хүлээн авч акт үйлдэх” дэд программуудыг 2020 оны бүртгэгдсэн өгөгдлийг архив хэсэгт шилжүүлж, 2021 оны бүртгэлийг хийж байна.
 - Газарзүйн мэдээллийн систем /ArcGis/-д суурилсан программ хангамжийг шинээр боловсруулан цахим бүртгэлийн программ хангамжийн “Тэг тэнхлэг”, “Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэгдсэн акт” хэвлэх дэд программуудыг боловсруулж байна.

- Спорт хамтлагийн ажлын хэсгийн хүрээнд албан хаагчдын дунд зохион байгуулсан Цахим алхалтыг тэмцээн зохион байгуулахад UDA draft дэд программ хангамжийг боловсруулсан.
10. Албан хаагчдын 548 дуудлагын дагуу программ хангамж, компьютер, хэвлэх хувилах төхөөрөмжийн гэмтлийг засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан.
 11. Хот байгуулалтын мэдээллийн сангийн программ хангамж, барилга байгууламжийг паспортжуулах ажилд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй судалгаа, холбогдох мэдээллийг гарган “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөлд хүргүүлсэн.
 12. Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолын дагуу мэдээллийн аюулгүй байдлыг Фортинэт загварын галт хана болон домэйн контроллер дээр зөвшөөрөлгүй веб хуудас болон зөвшөөрөлгүй программуудыг хязгаарлах арга хэмжээ авсан.
 13. Хурлын заалны тоног төхөөрөмжүүдийг цахим хурал, сургалт зохион байгуулахад бэлтгэн шинэчилсэн. Мөн цахим хурал зохион байгуулах zoom программын 100 хэрэглэгчийн эрхийг худалдан авч ашиглалтад оруулсан.
 14. Мэргэжлийн зөвлөлийн хурлын бэлтгэлийн хангаж, цахимаар зохион байгуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг холбож ажиллагаанд оруулсан.
 15. Хот байгуулалтын мэдээллийн менежментийн системийн 7 өгөгдлийн баазыг 3 удаа нөөцөлж авсан.

ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ХҮРЭЭНД

3.1 Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дагуу бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах:


1. Хэлтсийн үйл ажиллагааны тайлан, холбогдох үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүрд нэгтгэн Захиргаа, санхүүгийн хэлтэст өгсөн. Үүнд:
 - Хэлтсийн тайланг 7, 14 хоног, сар, улирал, хагас жил, жилийн эцсийн байдлаар,
 - Захиргааны зөвлөлийн хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын ажлын явцын мэдээ,
 - Засгийн газар болон Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тогтоол шийдвэрээс хэлтэст хамаарах заалтуудын биелэлт,
 - Барилга, хот байгуулалтын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2021 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээнээс хэлтэст хамаарах заалтуудын биелэлт,
 - Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийн хэрэгжилтээс хэлтэст хамаарах заалтуудын биелэлт.
 - Хэлтсийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, журмын жагсаалтыг хүснэгтийн дагуу гаргаж,
 - Улсын байцаагчийн албан даалгаврын биелэлтээс хэлтэст хамаарах заалтуудын биелэлтийг 10 дугаар сарын байдлаар,
 - Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтээс хэлтэст хамаарах заалтуудын биелэлт.
2. Засгийн газрын болон Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг боловсруулж хүргүүлсэн.
3. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/929 дүгээр захирамжийн дагуу хэлтсээс үзүүлдэг 5 төрлийн үйлчилгээний холбогдох эрх зүйн акт, баримт бичгийн бүрдлийн мэдээллийг өгөгдсөн хүснэгтийн дагуу нэгтгэн гаргаж Захиргаа санхүүгийн хэлтэс болон Хууль эрх зүйн хэлтэст өгөв.
4. Байгууллагад Нийслэлийн Аудитын газар, Дотоод Аудитын газраас хийсэн шалгалтын хүрээнд шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүрд гаргаж өгсөн.

3.2 Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, ажиллах:


1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу хэлтсийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан.
2. Хэлтсийн албан хаагчид дээрх тушаалын 6 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлуулж, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан.
3. Хэлтэс болон албан хаагчид дээрх тушаалын 7, 8 дугаар хавсралтын дагуу 2021 оны хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайлангаа гаргасан.

3.6 Нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнд хүрэх бодитой ажил санаачлан хэрэгжүүлэх:

1. 2021 онд хэлтсээс шинээр санаачлан хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “ЦАХИМ БАРИЛГЫН МЭДЭЭЛЭЛ” гар утасны апплейкшны танилцуулга, холбогдох мэдээллийг Нийслэлийн Засаг даргад танилцуулсан.
2. Газрын даргаас өгсөн үүргийн дагуу мэргэжлийн зөвлөлийн хурлын шийдвэрийг цахим болгох талаар судалгаа хийж www.mzh.uda.ub.gov.mn хуудсаар дамжин дэмжсэн, эс дэмжигдсэн саналыг цахимаар өгөх веб программ хангамжийг шинээр боловсруулсан.



3. Хот байгуулалтын кадастрын мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн www.urban.gov.mn цахим хуудсаар дамжуулан, барилгын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимаар хүлээн авч шийдвэрлэх Хот байгуулалтын ухаалаг системийг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Уг системийг нэвтрүүлснээр:
 - Иргэн, хуулийн этгээд төрд байгаа мэдээллийг дахин баталгаажуулах шаардлагагүйгээр цахим үйлчилгээ авах,
 - E-gazar.gov.mn Системтэй холбогдож өөрийн эзэмшил газрын мэдээллийг татан Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл, хамгаалалтын зурвастай давхцаж байгааг шалган барилгажих талбайг тооцоолох,
 - Барилга барих хүсэлтээ илгээх ба шийдвэрлэлтийн явцыг Хот байгуулалтын ухаалаг системд суурилсан гар утасны **АПЛИКЕЙШН** ашиглан хянах боломжтой болно.



Энэхүү системийн талаар Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуралд танилцуулсан ба 19 дүгээр хурлын тэмдэглэлээр уг ажлыг эрчимжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх үүрэг өгөгдсөн. Үүргийн дагуу нийслэлийн 2022 оны төсөвт тусгуулах саналыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Уг систем нь Монгол улсад хэрэгжиж буй төрийн үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia.mn төсөлтэй холбогдсон байх ба цаашид Улсын Хот байгуулалтын кадастрын нэгдсэн системтэй холбогдон ажиллах юм.



3.7 Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах:

1. Хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нар 2020 оны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд нь мэдүүлж, баталгаажуулсан.
2. Хэлтсийн албан хаагчид Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3.13 Иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж, албан хаагчдын баримт бичгийн боловсруулалтыг сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллах:

1. Иргэн, хуулийн этгээдээс <https://edoc.ulaanbaatar.mn/> цахим хуудсаар дамжин ирсэн 211 албан бичигт хариу өгч шийдвэрлэсэн бөгөөд албан бичиг шийдвэрлэлтийн хэлтсийн дундаж хугацаа 4.16 хоног байна.

2. www.erp.ulaanbaatar.mn цахим хуудсаар ирүүлсэн 47 өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн ба дунджаар 4 хоногт шийдвэрлэж байна.

3.14 Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах:

1. Газрын даргын 2019 оны А/58 тушаалын хэрэгжилтийг ханган, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

3.16 Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2020 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарьт хугацаанд холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх:

1. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2020 оны хэлтсийн хурлын тэмдэглэл, ирсэн бичиг, нийслэлийн гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах асуудлыг хэлэлцэх комиссын хурлын тэмдэглэл, холбогдох баримт бичиг, хаяг дугаар хүссэн өргөдөл иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох баримт бичиг, хаяг дугаар олгосон тодорхойлолт, бүртгэлийн дэвтэр, тэг тэнхлэгийн хүлээн авсан акт, тендерийн баримт бичгийн зэрэг нийт 78 боть, 3 төрлийн 9 цахим баримтыг байгууллагын архивд тогтоосон хугацаанд нь хүлээлгэн өгөв.
2. Геодези, зураг зүйн тухай хууль, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан журмын дагуу 2020 онд хот байгуулалтын мэдээллийн санд хүлээлгэн өгсөн 13 боть байр зүйн зургийн эх материал, тоон мэдээллийн Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Улсын нэгдсэн сангийн архивд хүлээлгэн өгсөн.
3. Мөн 2021 оны I, II, III улиралд Хот байгуулалтын мэдээллийн санд хүлээлгэн өгсөн иргэн, хуулийн этгээдийн захиалгаар хийгдсэн барилга, байгууламж, инженерийн шугам сүлжээний байр зүйн зургийн тоон мэдээллийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Улсын нэгдсэн сангийн архивд шилжүүлсэн.
4. Газрын даргын 2021 оны А/26 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд Төрийн архивд баримт шилжүүлэхээр бэлтгэж буй 2006-2011 оны цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, товьёг хийж хавтаслан 2007 оны 3, 2011 оны 10, 2016 оны 15, нийт 28 хайрцаг баримт материалыг Захиргаа, санхүүгийн хэлтэст хүлээлгэж өгөв.



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД


4.1 Газрын үйл ажиллагааг иргэдэд шүүрхай хүргэж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах:

1. Байгууллагын цахим хуудас дахь Улаанбаатар хотын гудамж, зам, талбайн нэршлийн жагсаалтыг 3 удаа шинэчилж байршуулсан.
2. Мөн шинээр нэршүүлсэн гудамжны талаар болон Барилгын зөвшөөрлийг цахимжуулахтай холбоотой мэдээлэл бэлтгэн байгууллагын www.uda.ub.gov.mn цахим хуудас болон facebook хуудсанд байршуулсан.
3. erp.ulaanbaatar.mn шинээр томилогдсон 22, ажлаас чөлөөлөгдсөн 24, шилжүүлэн томилогдсон 20 албан хаагчдын мэдээллийг газрын даргын тушаалын дагуу шинэчлэв.
4. Авлигын эсрэг авах арга хэмжээний хүрээнд цахим хуудсан дээрх санал хүсэлт илгээх модулийг шинэчилсэн.
5. Байгууллагын цахим хуудасны загвар, дизайныг шинэчилж, нийт 12 төрлийн 285 мэдээ, мэдээлэл байршуулсан.

• Цаг үеийн мэдээ	74
• Барилгын ажлын зөвшөөрлийн бүртгэл	9
• Мэргэжлийн зөвлөлийн хурал	29
• Бичгийн шийдвэрлэлт	22
• Өргөдөл гомдлын шийдвэрлэлт	10
• Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	32
• Газрын даргын тушаал	54

• Төсөв, санхүүгийн тайлан	18
• Хууль дүрэм журам	9
• Хүний нөөц	13
• Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	16
• Бусад	9






6. Байгууллагын цахим хуудасны Зөвшөөрөлтэй барилгын мэдээлэлд 2020-2021 онд зөвшөөрөл авсан 1832 барилгын мэдээллийг оруулж, холбогдох зөвшөөрлийн мэдээллийг байршуулж байна.



4.4 Байгууллагаас үзүүлдэг зарим үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн порталд холбох ажлын хүрээнд:

1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас ирсэн албан бичгийн дагуу e-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох байгууллагаас үзүүлдэг 17 төрлийн үйлчилгээний мэдээлэл болон шат дамжлагын талаарх дэлгэрэнгүй жагсаалтыг гаргаж албан бичгээр хүргүүлсэн.

- Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Аствишн ХХК-тай хамтран 3 дугаар сарын 26-аас эхлэн барилгад хаяг дугаар олгох, байр зүйн зургийг мэдээллийн санд бүртгэх, тэг тэнхлэгийн актыг мэдээллийн санд бүртгэх, инженерийн шугам сүлжээний зурган мэдээллээр үйлчлэх, архивын лавлагаа, Архитектур төлөвлөлтийн даалгавар олгох гэсэн 6 төрлийн үйлчилгээг төрийн үйлчилгээний нэгдсэн портал “e-mongolia”-д холбож, үйлчилгээ үзүүлж эхэлсэн бөгөөд тайлант хугацаанд Төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn-р **216**, Нийслэлийн нэгдсэн цахим үйлчилгээний www.eservice.ulaanbaatar.mn **1358**, нийт **1574** хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.



- Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн олгох, Барилгын эх загвар зураг батлах зэрэг 2 үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн портал www.e-mongolia.mn-д холбох хүсэлтийг Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газарт гаргаж, хөгжүүлэлтийн ажлыг “Аствишн” ХХК гүйцэтгэн үйлчилгээг нэвтрүүлэхэд бэлэн болгоод байна.

ХЭЛТСИЙН ДОТООД АЖИЛ

- Газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Хот байгуулалтын ухаалаг систем хөгжүүлэх, нэвтрүүлэх тухай танилцуулга бэлтгэсэн, Захиргааны зөвлөлийн хуралд танилцуулав.
- Хэлтсийн албан хаагчид дараах ажлын хэсгүүдэд гишүүнээр ажиллаж байна. Үүнд:
 - Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2021 оны А/20 дугаар тушаалаар байгуулсан үнэлгээний хороонд гишүүнээр хэлтсийн ахлах мэргэжилтэн ажиллаж, 6 удаагийн цахим хуралд оролцон холбогдох саналаа өгч ажилласан. Мөн “Ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл”-д гарын үсэг зурж баталгаажуулсан.
 - Газрын даргын 2021 оны А/09 дүгээр тушаалаар байгуулсан Ёс зүйн зөвлөлд хэлтсийн 1 албан хаагч ажиллаж 4 удаагийн хуралд оролцож холбогдох саналаа хүргүүлж ажилласан.
 - Газрын даргын 2021 оны А/05 дугаар тушаалаар байгуулсан Спорт хамтлагт хэлтсийн 1 албан хаагч ажиллаж, байгууллагын спортын арга хэмжээ зохион байгуулахад оролцсон бөгөөд хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдсан.
 - Газрын даргын 2021 оны А/15 дугаар тушаалаар байгуулсан Залуучуудын хөгжлийн зөвлөлд хэлтсийн 1 мэргэжилтэн ажиллаж, зохион байгуулалтын ажилд оролцож байна.
 - Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газраас 8 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан Залуучуудын хөгжлийн зөвлөлийн тэргүүнүүдийн хамтын ажиллагааны тухай цахим уулзалтад хэлтсийн мэргэжилтэн П.Цэрэндолгор оролцсон.
- Байгууллагаас болон бусад байгууллагаас зохион байгуулсан мэргэжлийн, төрийн албан хаагчийн ур чадварыг дээшлүүлэх дараах сургалтад хэлтсийн албан хаагчид хамрагдсан. Үүнд:
 - Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Мерит төслөөс хамтран зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ, үнэлгээ” цахим сургалт хэлтсийн бүх албан хаагч,

- b. Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан “Албан хэрэг хөтлөлт”-ийн талаарх цахим сургалтад хэлтсийн бүх албан хаагч,
- c. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Сургалт, судалгааны төвтэй хамтран зохион байгуулсан “Нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдыг чадавхжуулах” багц сургалтад гурван албан хаагч тус тус хамрагдсан.
- d. Хэлтсийн 2 албан хаагч газрын удирдлагуудын хамт 7 дугаар сарын 27-ны өдөр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний хөгжлийн газрын ухаалаг системтэй танилцаж, туршлага солилцов.
- e. Хил хамгаалах ерөнхий газраас зохион байгуулсан “Нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн туршилтын нислэг”-ийн танилцуулга сургалтад нэг албан хаагч,



- f. 9 дүгээр сарын 15-ны өдрийн Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад зориулсан хуулийн цахим сургалтад хэлтсийн 7 албан хаагч, 9 дүгээр сарын 16-ний өдрийн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт ба төрийн албаны шинэчлэлт цахим сургалтад хэлтсийн 7 албан хаагч,
- g. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан "Улс, нийслэлийн хөгжлийн бодлогын суурь үзэл баримтлал", "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Edoc системийн ашиглалт", "ERP системийн ашиглалт" сэдэвт нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагийн нэгжийн дарга нарт зориулсан багц сургалтад хэлтсийн дарга,
- h. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Сургалт судалгааны төвтэй хамтран зохион байгуулсан "Албан бичгийн найруулга зүй", "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, eDoc, ERP систем ашиглалт, өргөдөл гомдлын систем" сургалтад хэлтсийн 5 албан хаагч,
- i. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан Улс нийслэлийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийн танилцуулга, албан бичгийн журам, E doc, ERP, өргөдөл гомдлын системийн сургалтад хэлтсийн ахлах мэргэжилтэн,
- j. Нийслэлийн Сургалт, судалгааны төвөөс зохион байгуулсан Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан гарын авлагыг баталгаажуулах сургалтад нэг албан хаагч,
- k. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Төрийн захиргаа, удирдлагын хэлтсээс зохион байгуулсан "Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015 стандартыг байгууллагын ажиллагаанд нэвтрүүлэх ач холбогдол, үр дүн" сургалтад хэлтсийн дарга,
- l. Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Хууль, эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдад зориулсан хуулийн сургалтад бүх албан хаагч,
- m. Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газраас зохион байгуулсан "Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт ба төрийн албаны шинэтгэл" сэдэвт сургалтад бүх албан хаагч,

- n. Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Сургалт, судалгааны төвөөс зохион байгуулсан Төрийн албан хаагчийн манлайлал сэдэвт сургалтад 5 албан хаагч,
 - o. Тус газар, Young Brain Institute-тэй хамтран зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн манлайлал ба гүйцэтгэлийн менежмент" сэдэвт сургалтад бүх албан хаагч,
 - p. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Прокурор "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор төр, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах нь" сэдэвт сургалтад хэлтсийн дарга,
 - q. Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газраас зохион байгуулсан "Цогц чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага" сэдэвт сургалтад 6 албан хаагч,
 - r. Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан Худалдан авах ажиллагаатай холбоотой шинэчилсэн журам, тендерийн жишиг баримт бичиг, цахим системийн танилцуулаг сургалтад хэлтсийн ахлах мэргэжилтэн,
 - s. Удирдлагын академиас зохион байгуулсан "Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт "Алсын хараа-2050" сэдэвт сургалтад хэлтсийн ахлах мэргэжилтэн,
 - t. Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газраас зохион байгуулсан "Харилцааны ур чадвар" сэдэвт сургалтад бүх албан хаагч,
 - u. Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Сургалт, судалгааны төвөөс хамтран зохион байгуулсан "Хүний эрх ба ялгаварлан гадуурхалт", "Гэрч хохирогчийг хамгаалах үйл ажиллагаа" сэдэвт сургалтад бүх албан хаагч,
 - v. Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газраас зохион байгуулсан "Майер Бригстийн төрөл илтгэгч" хувь хүнийг тодорхойлогч үзүүлэлтийн танилцуулга сэдэвт сургалтад бүх албан хаагч,
 - w. Төрийн албаны зөвлөлийн Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газраас зохион байгуулсан "Албан хаагчийн зөөлөн ур чадвар хөгжүүлэх туршлага" сэдэвт сургалтад бүх албан хаагч,
 - x. Тус газрын Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс зохион байгуулсан Монгол бичгийн сургалтад нэг албан хаагч тус тус хамрагдав.
4. 7 дугаар сарын 27-ны өдөр 2 албан хаагч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний хөгжлийн газрын ухаалаг системтэй танилцаж, туршлага солилцов.
 5. Харилцаа холбооны зохицуулах хорооноос 11 дүгээр сарын 3-ны өдөр ГЗБГЗЗГ, УБЕГ, НГЗБА, "Монгол шуудан" ТӨХК-аас төлөөллүүд оролцсон "Хаягжуулалт, шуудангийн нэгдсэн код" сэдэвт танилцуулга сургалтыг зохион байгуулсан сургалтад 2 албан хаагч оролцож нийслэлийн хаягжуулалтын өнөөгийн байдлын талаар танилцуулсан.

НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР

1. Нийслэлийн Онцгой комиссоос өгсөн үүргийн дагуу 1 дүгээр сарын 26-29 өдөр Хан-Уул дүүрэгт эргүүлээр 1 албан хаагч, 2 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд Хан-Уул дүүрэгт 2 албан хаагч, 10 дугаар сарын 4-24 өдөр Сүхбаатар дүүргийн 12 дугаар хорооны өрхийн эмнэлэгт 3 албан хаагч тус тус ажилласан.
2. Улсын Онцгой комиссын 2021 оны 41 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Программ хангамж хариуцсан мэргэжилтэн Э.Насанбат дүүргийн Мэргэжлийн хяналтын газар болон Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн албан хаагчидтай хамт 6 дугаар сарын 21-30 өдрүүдэд Хан-Уул дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх худалдааны төв, ресторанд эрүүлээр ажиллав.
3. Газар, барилгажилтын мэргэжлийн зөвлөлийн хурлын танилцуулгыг шинэчлэгдсэн загвараар үзүүлэх үүрэг даалгавар өгсний дагуу ArcScene программ хангамж ашиглан Улаанбаатар хотын барилгыг гурван хэмжээсээр босгож, уг мэдээллийг мэргэжлийн зөвлөлийн хурлын танилцуулгад хэрхэн ашиглах болон видео хийх зааврыг бэлтгэж Хот төлөвлөлтийн хэлтэс, Хот дахин хөгжүүлэх хэлтсийн мэргэжилтнүүдэд өгсөн. Мөн Газар барилгажилтын мэргэжлийн зөвлөлийн 1 дүгээр хуралд шинэчилсэн танилцуулга бэлтгэхэд холбогдох мэргэжилтнүүдэд заавар, зөвлөгөөг өгч ажиллав.

4. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепцын хэлэлцүүлэг зохион байгуулах төлөвлөгөө, хэрхэн зохион байгуулах талаар болон холбогдох зардлыг судалж Ерөнхий архитекторын ажлын албанд өгөв.
5. Газрын даргаар баталсан хуваарийн дагуу 7 дугаар сарын 14-ний өдөр хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нар 24 цагийн хариуцлагатай жижүүрээр ажиллаж, цагийн мэдээг Нийслэлийн шуурхай штабын утсанд өгсөн.
6. Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны иргэдээс гаргасан гомдлын дагуу 7 дугаар сарын 27-ны өдөр иргэн Б.Билгүүний албан контор, үйлчилгээний зориулалттай барилгад хяналтын хэмжилт хийж, хэмжилтийн өгөгдлийг Хот дахин хөгжүүлэх хэлтсийн Хот төлөвлөлтийн мэргэжилтэнд өгөв.
7. 7 дугаар сарын 29, 9 дүгээр сарын 16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Хот байгуулалт, төлөвлөлтийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох, хот төлөвлөлтөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг шуурхай хүргэх системийг боловсруулах талаар Азийн хөгжлийн банкны төлөөлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын хамтарсан цахим хуралд хэлтсийн дарга оролцсон. Уг хурлаар хэлэлцсэний дагуу боловсруулахаар төлөвлөж буй системийн талаарх танилцуулгыг монгол, англи хэлээр бэлтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэст хүргүүлсэн.
8. Хот төлөвлөлтийн хэлтэс болон Барилгын чанар, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн хүсэлтийн дагуу зөвшөөрөлгүй барилга, байгууламжийг тодруулах, орон зайн дүн шинжилгээ хийхэд шаардлагатай байр зүйн зургийг 12 байршилд хийж гүйцэтгэсэн.
9. Туул-1 коллекторын ажлын даалгавар шинэчлэн боловсруулах ажилд геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн оролцож, Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлэв.
10. Дархан цаазат Богдхан уулын тусгай хамгаалалттай газар нутагт байрлах иргэн, хуулийн этгээдийн газар ашиглалтын болон барилгын зөвшөөрлийн үйл ажиллагаа, авлига албан тушаалын гэмт хэргийн зөрчлийг шалгах ажлын хэсгийн хүрээнд геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн С.Пүрэв-Очир 8 дугаар сарын 20-31 хооронд Авлигатай тэмцэх газар, Эрүүгийн цагдаагийн газрын албан хаагчдын хамт хяналт, шалгалтын ажлаар явж, холбогдох мэдээ, тайланг гаргаж өгсөн.



11. Газрын даргаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Хот төлөвлөлтийн хэлтэстэй хамтран Богдхан уулын хязгаарлалтын бүсэд оруулах өөрчлөлтийн санал, холбогдох судалгаа, сэдэвчилсэн зураг, танилцуулга бэлтгэв.
12. Мөн Их тойруу дахь төрийн байгууллагын барилгын тоо, сэдэвчилсэн зураг бэлтгэв.
13. Нийслэлийн Онцгой комиссын даргын 2021 оны 08 дугаар тушаалын дагуу Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабын Мэдээлэл технологийн багийн Орон зайн дүн шинжилгээний бүлэгт тус хэлтсийн 3 албан хаагч 2 дугаар сарын 3-аас 6 дугаар сарын 4-ний хооронд ажиллаж доорх ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:
 - Нийслэлд бүртгэгдсэн Ковид-19 халдварын тохиолдлуудыг орон зайн мэдээллийн системд бүртгэх, бүртгэгдсэн тохиолдлуудын мэдээллийг шалгаж, засварласан.

- Улаанбаатар хот дахь тусгаарлах байрны мэдээллийг орон зайн мэдээллийн системд бүртгэсэн.
 - Нийслэлийн мэдээ цахим хуудсанд тавигдах Орон зайн дүн шинжилгээний бүлгийн мэдээний эх, Ковид-19 халдварын тархалтын сэдэвчилсэн зураг бэлтгэж, хэвлэсэн.
 - Монгол улсын Онцгой комиссын даргын 2021 оны 21 дүгээр тушаалаар батлагдсан Хот хоорондын зорчих тээвэрлэлтийг зохицуулах түр журамтай холбоотой тус багаас хийх ажлын төлөвлөөг боловсруулж холбогдох нэгжид хүргүүлж, Нийслэлийн авто тээврийн товчоодын мэдээлэл, тэдгээрээр гарсан, орсон тээврийн хэрэгслийн тоон мэдээллийг тогтмол шинэчилсэн.
 - Орон зайн мэдээллийн сангийн суурь өгөгдөл, батлагдсан тохиолдлын орон зайн мэдээллийг ArcGIS, ArcScene программ хангамж ашиглан тархалт, нягтралын дүн шинжилгээ хийж А0 хэмжээтэй сэдэвчилсэн зураг, гурван хэмжээст дүрс бичлэгэн танилцуулга бэлтгэж холбогдох багт хүргүүлж ажилласан.
 - Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын “Орон зайн мэдээ” сэтгүүлд нийтлүүлэх “Ковид-19 халдварын тархалтын орон зайн дүн шинжилгээ”-ний тухай эрдэм шинжилгээний өгүүллэгийг англи, монгол хэл дээр бичиж хүргүүлсэн.
 - Нийслэлийн онцгой комиссын 2021 оны 71 дүгээр албан бичгээр Дүүргүүдийн Онцгой комисст Орон зайн дүн шинжилгээний товч тайлан, мэдээг холбогдох газруудад хүргүүлсэн.
 - Нийслэлийн онцгой комиссын шуурхай штабт А0 хэмжээгээр 13, А1 хэмжээгээр 5, нийт 18ш зураг хэвлэж өгсөн.
 - Нийслэлийн Цагдаагийн удирдах газарт Улаанбаатар хотын 6 дүүрэгт төлөвлөлт, хамгаалалт /эргүүл/ хийх байршил, албан хаагчдын бүртгэлийг хянах, харах эрхтэй веб хуудас хийж тус газарт хүлээлгэж өгсөн.
 - Нийслэлийн 9 дүүргийн орон зайн мэдээлэл бүрдүүлэх, төлөвлөлт боловсруулах web хуудсыг хянаж, засварлаж, хандах эрхийн зохицуулалт хийж, заавар өгч ажилласан.
 - Нийслэл хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа дэлгүүр, зах, худалдааны төвүүдийн мэдээллийг орон зайн мэдээллийн системд бүртгэж ArcGIS Online программ хангамж ашиглан цахим хуудас үүсгэсэн.
 - Өдөр бүрийн 10:00, 14:00, 18:00 цагт багийн үйл ажиллагааны тайлан мэдээг нэгтгэн Нийслэлийн Онцгой комиссын холбогдох багт тогтмол өгсөн.
 - Нийслэлийн Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэж тухай бүрд шаардлагатай мэдээллээр хангаж, бүрдүүлж, тайлагнаж ажилласан.
14. Нийслэлийн Онцгой Комиссын 2021 оны 659 дугаартай албан бичгийн хүрээнд батлагдсан хуваарийн дагуу Нэгдсэн шуурхай штабт 11, 12 дугаар сарын амралтын өдрүүдээр ажиллаж цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж хэлтийн 2 мэргэжилтэн ажиллаж байна.



15. Мөн Нийслэлийн Онцгой Комиссын 2021 оны 726 дугаар албан бичгээр ирсэн хуваарийн дагуу 11 дүгээр сарын 30-аас 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл их, дээд

сургуулиуд дээрх дархлаажуулалтын ажилд хяналт тавин Нийслэлийн онцгой комисс, Боловсрол, шинжлэх ухааны яамд мэдээлэл өгч хэлтсийн 2 албан хаагч ажиллаж байна.



16. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/779 дүгээр захирамжийн хүрээнд ХУД-ийн 9 дүгээр хороог хариуцан ажиллаж, түгээлтийн цэгүүдийн байршил, хүчин чадал, нөөцийн хэмжээ, түлшний чанар, хүртээмж бодит байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулан, түлш түгээлтийн цэгт ажиллаж байгаа иргэдээс ирсэн санал хүсэлт, тулгамдаж буй асуудлын талаар тухай бүрд нь "Таван толгой түлш" ХХК-д мэдээлж ажиллав.
17. Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм болон Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэмд оруулах санал, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас боловсруулсан 18 стандартад тус тус санал хүргүүлэв.
18. Сэлбэ голын онцгой, энгийн хамгаалалтын бүс, Сэлбэ гол дагуух хурдны замын трасст орсон газар болон барилга байгууламжийн судалгааг гаргаж Газрын даргад танилцуулав.
19. Хэлтсийн албан хаагчид төрийн албан хаагчийн анкет болон ажил байдлын тодорхойлолтуудыг шинэчлэн Захиргаа санхүүгийн хэлтэст өгөв.
20. Хэлтсийн албан хаагчид Ковид-19 халдварын эсрэг 3 тун вакцинд бүрэн хамрагдсан.
21. Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан 1 тэрбум мод тарих үндэсний хөтөлбөрийн хүрээнд 10 дугаар сарын 9-ний өдөр Баруун салаанд, 10 дугаар сарын 12-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд тус тус мод тарих үйл ажиллагаанд албан хаагчид оролцов.

ХЯНАСАН ХЭЛТСИЙН ДАРГА:

А.АМАРСАНАА

НЭГТГЭСЭН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН:

О.БАЯРМАА